



**БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/24

Хөхбүрд

**Г Малчдын хаваржилтад туслах ажлын
хэсгийг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Онцгой комиссын даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малчид төлчдийн хаваржилтийн байдалтай газар дээр нь очиж танилцаж, зорилтот бүлгийн 15 өрхөд хүнс болон өвс тэжээлийн тусламж болох 4.999.500 (Дөрвөн сая есөн зуун мянга ерэн есөн мянга таван зуун) төгрөгийг өгөх арга хэмжээг авч ажиллах зорилгоор төрийн албан хаагчдыг 4 багт дайчлан ажиллах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Багийн малчдад хивэг тараах ажлыг өгсөн үүрэг даалгаврын дагуу цаг тухай бүрт нь биелүүлж, бүртгэл хөтлөн тайлагнаж ажилахыг багийн Засаг дарга нар болон ажлын хэсгийн ахлагч, ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд 2023 оны 04 дүгээр сарын 07-ны дотор хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Ганцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР

642201149

Сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 29-ны өдрийн 424 дүгээр
Захирамжийн нэгдүгээр хавсралт

Малчдын хаваржилтын нөхцөл байдалд туслах байдлаар өвс тараах 4 багт
хуваарилагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

1. Мандалхайрхан нэгдүгээр багт ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:
 - Ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчид
2. Уранхайрхан хоёрдугаар багт ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:
 - Засаг даргын Тамгын газрын албан хаагчид
3. Асгамба гуравдугаар багт ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:
 - Эрүүл мэндийн төв болон Соёлын төвийн албан хаагчид
4. Мэргэн дөрөвдүгээр багт ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүн:
 - Цэцэрлэгийн албан хаагчид

-----oOo-----

Сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 424 дүгээр Захирамжийн хоёрдугаар хавсралт

ХАВАРЖИЛТИЙН БЭЛТГЭЛ БАЙДАЛТАЙ ТАНИЛЦАХ УДИРДАМЖ

2023 оны 03 дугаар сарын 20

Хөхбүрд

Нэг.Зорилго. Сумын Малчин иргэдийн хаваржилтийн нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцах, хүндрэлтэй нөхцөл байдлыг илрүүлэх, Эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай арга хэмжээг авч шуурхай ажиллах, сургууль, цэцэрлэгт хамрагдах боломжгүй байгаа хүүхдүүдэд мэдээлэл өгөх, эцэг эхчүүдэд сурган хүмүүжүүлэх арга барилын талаар тодорхой мэдлэг, мэдээллийг түгээж ажиллах.

Хоёр. Зорилт: Малчид, төлчдийн хаваржилтийн ажилд төрөөс үзүүлэх арга хэмжээг түргэн шуурхай авч хэрэгжүүлэх, цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийн хичээл сурлагын байдалтай танилцах ажлыг хамтарсан багийн зүгээс зохион байгуулан, хүүхдийн хүмүүжил төлөвшилийн талаар сургалт мэдээллийг өгч ажиллах.

Гурав.Хугацаа: 2023 оны дугаар сарын ...-ны өдөр ажлын хэсэг гарч ажиллана.

Дөрөв.Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:

№	Ажлын хэсгийн ахлагч	Гишүүдэд			
1	1 дүгээр багийн Засаг дарга	Засаг даргын орлогч	1 дүгээр багийн эмч	1 дүгээр багийн малын эмч	Сургуулийн нийгмийн ажилтан
2	2 дугаар багийн Засаг дарга	Засаг дарга	2 дугаар багийн эмч	2 дугаар багийн мзалын эмч	Хөдөлмөр эрхлэлт, Халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
3	3 дугаар багийн Засаг дарга	Тамгын газрын дарга	3 дугаар багийн эмч	3 дугаар багийн малын эмч	Нийгмийн эрүүл мэндийн ажилтан
4	4 дүгээр багийн Засаг дарга	Иргэдийн хурлын дарга	4 дүгээр багийн эмч	Малын эмч	Нийгмийн бодлогын мэргэжилтэн